

## ХОА БИНЬ МУЖИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ

Written by hanoi

Tuesday, 26 June 2018 03:47 - Last Updated Tuesday, 26 June 2018 03:49

---

There are no translations available.



Элчин сайд Д.Билэгдорж Вьетнамын Хоа Бинь мужийн Ардын зовлолийн дарга богоод Үндэсний Ассамблейн гишүүн, Үндэсний Ассамблей дахь Вьетнам-Монголын парламентын бүлгийн дэд дарга Чан Данг Нинь тэргүүтэй толоологчдийг хүлээн авч уулзан, хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны талаар санал солилцов.

Монгол Улсын Их Хурлын дарга М.Энхболд энэ оны 1 дүгээр сард Вьетнамд айлчлах үеэр "Монгол Улсын Төв аймаг, БНСВУ-ын Хоа Бинь мужийн хооронд хамтран ажиллах Санамж бичиг" байгуулсанд талууд сэтгэл хангалуун байна гээд цаашид үр дүнтэй хэрэгжүүлэхэд идэвхтэй хамтран ажиллахаа илэрхийллээ.